



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

67123. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2020.08.12 № 01/495
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ ШУДАРГА ИРГЭДИЙН НЭГДСЭН
ЭВСЭЛ НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт


Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050” болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын сонгуулийн мөрийн хөтөлбөр /....хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт / хуудастай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 О.ГАНБОЛД

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР



Э.БАТ-ЭРДЭНЭ